



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/177

Чингис хот

Нийтийн цэвэрлэгээ, ариутгал
халдваргүйжүүлэлтийн ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а, в, е", 30 дугаар зүйлийн 30.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 102 дугаар тогтоолын 4 дүгээр заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь

1. Аймгийн нутаг дэвсгэрт нийтийн цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэлийн ажлыг 2020 оны 03 дугаар сарын 29-ний өдрөөс 04 дүгээр сарын 05-ны өдрүүдэд гүйцэтгэж шаардагдах хөрөнгө, зардлыг орон нутгийн төсөв, гамшгийн эрсдэлийн сангаас зарцуулан ажиллахыг сумын Засаг дарга, тосгоны Захирагч нарт үүрэг болгосугай.

2. Ариутгал халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулах, мэргэжлийн аргачлал, заавар зөвлөмжөөр хангаж, машин тоног төхөөрөмжөөр дэмжин хамтран ажиллаж гүйцэтгэлийг нэгтгэн танилцуулахыг Зоонозын өвчин судлалын төв ийн дарга /Г.Наранхүү/, Онцгой байдлын газрын дарга /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/, Мал эмнэлгийн газар дарга /Н.Анхбаяр/, сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т даалгасугай.

4. Өөрийн эзэмшлийн газар, байгууллага, объектод цэвэрлээ, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг тогтмол хийж ажиллахыг нийт иргэд, төрийн байгууллага, аж ахуй нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА